



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН АЛБАН ДААЛГАВАР

2016 оны 06 сарын 09 өдөр

Дугаар 08

Өлгий

Үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх,
хамгаалах тухай

Манай орны нийт нутгаар 2015-2016 оны өвлийн улиралд цас их орж дулааны улирал эхэлж цасан бүрхүүл хайлсны улмаас гол, мөрний усны түвшин нэмэгдэж өнөөдрийн байдлаар Бугат, Буянт, Сагсай, Өлгий сумдын нутагт нийт 4 удаагийн үер, усны дуудлага гараад байна.

Иймд аймгийн Онцгой комиссын 2016 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх "Үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх" ажлыг эрчимжүүлэх зорилгоор дараах АЛБАН ДААЛГАВРЫГ хүргүүлж байна.

Нэг. Сумдын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт ДААЛГАХ нь:

1. Цаг агаарын мэдээ мэдээллийг тогтмол авч, болзошгүй гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах талаар иргэдэд шуурхай хүргэх ажлыг тасралтгүй зохион байгуулах.
2. Үер, усны аюулд өртөж болзошгүй голын арал, тохой, томоохон гол, нуурын эрэг дагуу, уулын усны буулт, жалга, судгийн аманд бууж суурьшсан айл өрхийн судалгааг гаргаж аюулгүй бүсэд нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ авах.
3. Бага насны хүүхдийг хараа хяналтгүй гол, мөрний эргээр явуулахгүй байх талаар гэр бүл, асран хамгаалагчдад зөвлөх, иргэд болгоомжгүй байдлаас усанд осолдож, амь насаа алдахаас урьдчилан сэргийлж анхааруулах тэмдэг, тэмдэглэгээг байрлуулах.
4. Үерийн хамгаалалтын далан, зам талбайн ус зайлуулах зориулалтын инженерийн байгууламжид үзлэг шалгалт хийх, үерийн далан, сувгийн цэвэрлэгээг тогтмол хийж, үерийн усны чөлөөтэй урсах нөхцөлийг бүрдүүлэх, албан байгууллага, шатахуун түгээх станцуудын аянга залуулагчийн ажиллагааг шалгах.
5. Үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх тухай сэрэмжлүүлгийг орон нутгийн радио телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгслээр гаргах, уулзалт ярилцлага зохиох, зурагт хуудас, санамж бичиг хэвлүүлэн тараах, зам, овоо харуулын байрны дэргэд зорчих газар харагдахуйц өндөрлөг газруудад үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх анхааруулсан замын тэмдэг, самбар байрлуулах зэргээр сурталчилгааны ажлыг зохион байгуулах.

Хоёр. Өлгий сумын Засаг дарга, Онцгой комиссын гишүүн Ө.Хабайд ДААЛГАХ нь:

1. Үер, усны аюулд өртөж болзошгүй голын арал, тохой, томоохон гол, нуурын эрэг дагуу, уулын усны буулт, жалга, судгийн аманд бууж суурьшсан айл өрхийн судалгааг гаргаж аюулгүй бүсэд нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ авах.
2. Үерийн ам, Ховд голын эргээр зөвшөөрөлгүй хашаа байцан барьсан айл өрхийн судалгааг гаргах.
3. Өлгий сумын төвийн ус зайлуулах сувагуудад цэвэрлэгээ хийх, хаагдсан сувагуудыг нээх ажиллагаа зохион байгуулах.
4. Өлгий сумын нутаг дэвсгэр дэх далангийн хамгаалалт, арчилгааны ажилд үзлэг

Гурав: Хилийн цэргийн 0165 дугаар ангийн захирагч /хурандаа Б.Мөнхбат/, 0285 дугаар ангийн захирагч /хурандаа Ш.Баатарсүх/, Зэвсэгт хүчний 340 дугаар ангийн захирагч /дэд хурандаа Б.Дорждэрэм/, Зэвсэгт хүчний 084 дүгээр уулын ротын захирагч /ахлах дэслэгч Б.Баттүвшин/ нарт ДААЛГАХ нь:

1. Үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах ажиллагаанд хил хамгаалах анги, заставт үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдыг сургаж, бэлтгэх, холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэр, албан даалгаврыг сурталчлах ажлыг зохион байгуулах.

2. Үер, усны аюулт үзэгдлийн үед туулах чадвар сайтай тээврийн хэрэгсэл, албан хаагчдыг татан оролцуулах, бие бүрэлдэхүүнийг шаардлагатай техник хэрэгслээр хангах.

Дөрөв: Аймгийн Онцгой комиссын орлогч дарга, Онцгой байдлын газрын дарга, /онцгой байдлын хурандаа Ц.Баттулга/-д ДААЛГАХ нь:

1. Үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээнд иргэдийг сургах, холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэр, албан даалгаврыг сурталчлах үер, усны үед ажиллах мэргэшсэн баг зохион байгуулж тэдний сургалт бэлтгэлийг хангах.

2. Онцгой байдлын газрын бие бүрэлдэхүүний үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах техник, тоног төхөөрөмжийн бэлтгэл бэлэн байдлыг хангуулах.


3. Үер, усны аюулын үед гамшгаас хамгаалах албад, тусгай төрөл мэргэжлийн ангийг удирдлагаар хангаж, шаардлагатай тохиолдолд удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах.

4. Орон нутгийн телевиз, радио, олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан иргэд, олон нийтэд үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглээр сэрэмжлүүлэг, ухуулга, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах.

5. Гамшигт болон аюулт үзэгдлийн үед сум, албан газар, аж ахуйн нэгж байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж, гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийг удирдлагаар хангаж, шаардлагатай тохиолдолд дайчлагдан ажиллах хүн хүч, машин техник, хэрэгслийн судалгааг гаргаж, шуурхай ажлын төлөвлөгөө боловсруулж ажиллах.

Албан даалгаврын биелэлтийг хангах ажлын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээ, тайланг 07 дугаар сарын 15, 09 дүгээр сарын 10-ны дотор Онцгой байдлын газарт ирүүлж, ажлын чанар, үр дүнг нэгтгэн дүгнэж аймгийн Онцгой комиссын даргад танилцуулахыг /онцгой байдлын хурандаа Ц.Баттулга/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Х.ДАРМЕН